

**МОНГОЛЫН ТӨР ЁСНЫ
УЛАМЖЛАЛЫН АСУУДАЛ**

Н. ИШЖАМЦ

БНМАУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүн

БНМАУ, түүний төрийн бүрэн эрхт байдал нь өнгөрсөн үеийн Монголын бүх түүхэн дэвшил хөгжлийн үр дүн мөн бөгөөд Монголын төр ёс нь олон зуун жилийн бат уламжлалтай билээ.

Монгол, Зөвлөлтийн археологич нарын шинжилгээний үр дүнгээс үзэхэд Монгол оронд одоогоос 300 гаруй мянган жилийн өмнө хуучин чулуун зэвсгийн үеийн мичин хүн оршин амьдарч байсан нь тодорхой болсон юм. Хуучин, шинэ чулуун зэвсгийн үе болон хүрэл зэвсгийн үед ч гэсэн Монголд хүй нэгдлийн байгуулал зонхилж байсан учир төр улс хараахан үүсч бий болоогүй байсан юм. Хүрэл зэвсгийн үед Төв Ази, түүний дотор мөн Монгол оронд нүүдлийн мал аж ахуй бүрэлдэн тогтож, аажмаар адуун сүрэг чухал үүрэг гүйцэтгэх болж, төмрийн үйлдвэрлэл үүсч хөгжсөн явдал хүй нэгдлийн үеийн овог, аймгийн байгуулал задарч, анхны ангит нийгэм, төр улс үүсэн бүрэлдэхийн урьдчилсан бэлтгэл болсон юм.

Хүрэл зэвсгийн үе, төмрийн эхэн үед нэгэнт бий болж, удтал оршин тогтнож удаа дараалан нийлж, салж байсан томоохон аймгуудын холбооны суурин дээр Монгол оронд анхны төр улсын бүрдлүүд үүссэн юм. М.Э.Ө. III зууны үед Монгол орны төв ба өмнөд хэсэгт оршин амьдарч байсан нүүдлийн малчин Хүннү нарын 24 аймаг нэгдэж, аймгийн холбоо байгуулсны үндсэн дээр Хүннү гүрэн байгуулагдсан нь Төв Ази, тухайлбал Монголд үүссэн анхны ангит нийгмийн шинжтэй төр улсын бүрдэл байв.¹ Хүннү гүрнийг мөхсөний дараа М. Э. I зууны үед Монгол ба нийт Төв Азийн улс төрийн тавцан дээр гарч ирсэн Сяньби улс бол бас хүннүгийн нэгэн адил нүүдэлчдийн анхны төр улсын бүрдлүүдийн нэг байсан юм. Хэл ба удам угсааны хувьд Хүннү нар нь өвөг монгол буюу эсхүл Монгол-түрэг угсааны аймгууд байжээ. Сяньби нарыг олонхи эрдэмтэд өвөг монгол хэлтэн аймаг байсан гэж бараг нэг дуугаар нотолдог юм. Хүннү, Сяньби нар хэл, удам угсааны хувьд чухам ямар байлаа ч гэсэн Монголын анхны төр улсын бүрдлүүдийг үүсгэсэн томоохон аймгууд байсан бөгөөд эцсийн эцэст чухам тэдний үед Монголын төр ёсны уламжлалын эх үндэс тавигдсан гэж үзэхэд болох мэт санагддаг юм.

Хүннү гүрэн, Сяньби улсын төрийн засаг захиргааны байгуулал зэрэг нь өмнөх үеийн аймгуудын холбооны захиргааны байгуулалтай олон талаар төсөөтэй, ялангуяа анхан үедээ зарим талаар бараг ялгарах юмгүй мэт байсан боловч үнэн хэрэг дээрээ аль аль нь нүүдлийн сурвалжит язгууртны зүгээс харъяат аймаг, овгуудыг баримтлан захирах, гадаад харилцааны идэвхтэй үйл ажиллагаа өрнүүлэх ба бусад улс оронд довтлон түрэмгийлэх бодлогыг эрхлэн явуулдаг чухамхүү улс төр, за-

1 Owen Lattimore, *Inner Asian Frontiers of China*, N. Y. 1951, pp 355, 452, 463—68.

саг захиргаа, цэрэг дайны албадлага, хүчирхийллийн аппарат буюу жинхэнэ төр улсын бүрдлийн шинжийг бүрэн хадгалсан байв.

Соёлын хувьд авч ярьвал хуучин чулуун зэвсгийн үеэс эхлээд Монголд оршин амьдарч байсан бүх овог, аймгууд тус тус өөрийн гэсэн эдийн боловсрол, оюуны соёлтой байсаар ирсэн нь археологийн шинжилгээгээр бүрэн нотлогдсон юм. Нүүдлийн мал аж ахуй Монгол ба Төв Азийн бусад зарим район, Ази, Европын хээр талын өргөн уудам бүс нутагт зонхилох болсон цагаас эхлэн зэргэлдээх газар тариалан, гар урлал эрхэлсэн улс орнууд ба хот улсуудын төр улс, бичиг үсгийн боловсролтой суурьшмал иргэншилт соёлоос ялгаатай нүүдэлчдийн соёл ялгаран гарч ирсэн байна. Хүннү, Сяньбийн үед нэгэнт төр улс, мөн, Ази Европын хээр талын бүс нутагт нэлээд дэлгэрч байсан, скандинавын «рүн» бичиг гэж алдаршсан хожмын Орхон-Енисейн түрэг бичгийн маягийн бичиг үсгийн боловсролын эх үүсвэр бий болж, нүүдэлчдийн соёл нь бас олон талаар жинхэнэ иргэншилт соёлын шинж төрхийг олсон байна. Хүннү, Сяньби нарын дунд үүссэн төр улсын бүрдэл, түүний засаг захиргааны аппарат, дотоод бодлого, гадаад харилцааны дэг журам нь гол төлөв улс төрийн шинж чанартай байсан боловч чухамхүү тийм шинжийг олсноороо бас тэдний иргэншилт соёлынх нь нэг чухал хэсэг, гол илрэлийнх нь нэг байсан гэж үзэхэд болмоор байдаг юм. Хүннү, Сяньбийн үеэс эхлэн тийнхүү Монголд Төв Азийн нүүдэл иргэншлийн эх үндэс тавигдсан бөгөөд тэр цагаас эхлэн Төв Азийн нүүдэл иргэншлийн уламжлал тогтож, аажим боловч тасралтгүй үргэлжлэн хөгжсөөр ирсэн юм.

Төр ёсны уламжлал, залгамжийн талаас авч яривал Хүннү, Сяньби нарын үеэс эхлэн Монголд оршин тогтнож байсан Жужан, Түрэг, Уйгурын хаант улс, Кидан гүрэн, язгуурын Монгол улс зэрэг нь нэг нэгний дараа шууд залган улс төрийн тавцан дээр гарч ирж байснаар барахгүй, түрүү түрүүчийнхээсээ төр ёс, засаг захиргаа, цэрэг иргэний ба соёлын олон зүйлийг уламжлан авч хэрэглээд улам улмаар нарийсган хөгжүүлж байжээ. Хүннү гүрний төрийн тэргүүн буюу хаан нь шаньюй (хаан) гэгддэг байсан бөгөөд төрийн тэргүүн, хаан сууж улс орныг баримтлан захирах ёс Хүннүгээс үүсэн уламжлагдсан байна. Сяньби нарын үеэс эхлээд төрийн тэргүүнийг «хаан» гэж цоллон нэрлэх уламжлал тогтож, Монголын түүхэнд удал хадгалагдан үлдсэн байна. Төрийн бичээчийн тушаал хүннүгийн үеэс эхлэн дараа дараагийн улс, ханлигуудад уламжлагдаж ирсэн байна. Хүннү, Сяньби нар улс орноо төв их гол, зүүн баруун гар буюу жигүүр гэж гурван том хэсэгт хуваан, хэсэг тус бүрийг түмт, мянгат, зуут, аравт болгон аравтын тогтолцоогоор нэгжлэн хувааж захирдаг засаг захиргаа, цэрэг иргэний хувиартай байсан нь мөн Жужан, Түрэг, Монголд уламжлагдан үлдсэн байна. Хүннү, Сяньби нарын ердийн хууль, алба гувчуур хураах журам нь хүртэл хойч үеийн Монголын түүхэнд их, бага хэмжээний өөрчлөл хувиралтайгаар уламжлагдан үлдсэн байдаг. Хүннү гүрний нийслэл Луут хот (Лүнчэн), Сяньби улсын хаадын өргөө ордон нь Хангайн нуруу, Орхоны хөндийд байсан бөгөөд хойч үед Монголд оршин тогтнож байсан янз бүрийн төр улсын нийслэл хот, хааны өргөөнүүд нь дийлэнх ихэнхдээ мөнхүү Хан тайн нуруу, Орхоны хөндийд байсаар ирсэн юм.

М.Э. IV-XIII зууны үеийн Монголд нүүдлийн феодализм үүсэн бүрэлдэж байсан түрүү феодализмын үеийн хаант улсууд оршин тогтнож байсан юм. IV-VI зууны Ар Монголд түрүү феодализм буюу феодалын эхэн түрүү үеийн монгол угсааны Жужааны хаант улс оршин тогтнож байжээ. Мөн тэр үеэр Өмнөд Монгол, Умард Хятадад өөр нэг

монгол угсааны Тоба нарын Умард Вэй улс ноёлж байсан нь үндсэндээ Жужаны хаант улсын нэгэн адил феодалын түрүү үеийн улс байв. Тудан, Тоба нарын төрийн тэргүүнүүд нь бас бусад монгол, түрэг угсаатны төрийн тэргүүн нарын нэгэн адилаар «хаан» гэдэг цол хэрэглэх байсан бөгөөд Жужаны хаан нь биеэ «фүгүдүн хан» буюу «бүгдийн хаан» хэмээн өргөжлүүлж байжээ. Жужан нарын нийгэм-улс төрийн байгуулал нь урьдах үеийн Хүннү, Сяньби нарынхаас нэлээд нарийсан хөгжсөн байдалтай байжээ. Жужан нар Хүннүгээс «рүн» бичиг өвлөн залгамжилж авсан гэж Е. Блоше, А. Рона Таш нарын зэрэг зарим эрдэмтэд үздэг байна.² Жужаны хаант улсад ердийн хууль, зарга заалихайн хэрэг эрхэлдэг төрийн зарлачийн тушаал нэгэнт бий болсон байсан нь дараах үеийн Түрэг, Уйгур нараар дамжин язгуурын Монголчуудын дунд нэвтэрч хэрэглэгдсэн байдаг. Жужаны хаант улсын нийслэл Мүмо хот Орхон, Тамирын сав газарт байсан тухай хятад түүхийн сурвалжид заасан байдаг бөгөөд археологийн шинжилгээгээр тэндээс илрэн олдсон зарим хот суурины туурийг түүнтэй холбон үздэг юм.

VI—VIII зууны үеийн Монгол оронд Түрэгийн хаант улс, VIII—IX зууны үед Уйгурын хаант улс, X—XII зууны үед Монгол угсааны Кидан гүрэн³ оршин тогтнох байсныг та бид сайн мэднэ. Түрэг, Уйгурууд угсаа гарвалийн хувьд хэдийгээр Монгол угсааны биш, түрэг хэлтэн аймгууд байсан боловч эрт дээр цагаас Монгол нутагт монголчуудын өвөг дээдэстэй зэрэгцэн оршиж, хамтран амьдарч байсан юм. Түрэгүүдийн ууган нутаг нь Алтайн нурууны орчин тойронд, Уйгурууд Сэлэнгийн дунд урсгалаар гол төлөв нутаглаж байсан боловч Түрэгийн хааны өргөө ордон болон Уйгурын хаант улсын нийслэл Хар балгас хотын аль аль нь Мөн Хангайн уул, Орхоны хөндийд байжээ. Түрэг, Уйгур нар бас Хүннү, Сяньби, Жужаны үеийн уламжлалыг дагаж төр улсынхаа улс төрийн төвийг Орхоны хөндийд байрлуулж байсан нь Монголын төр ёсны уламжлалын бас нэг анхаарууштай сонин үзэгдэл мөн гэвэл зохих мэт санагдана. Түрэг, уйгуруудын аль аль нь түрэг угсааны төрөл аймгууд байж, нэг нь нөгөөгийн халааг шууд залгаж авсан байтлаа уйгурууд түрэгийн рүн бичгийг хэрэглэхээ больж, арамей-Согдын гаралтай өөр бичиг авч хэрэглэсэн нь Монголын түүхэнд Уйгур бичиг буюу уйгуржин үсэг гэж алдаршаад, хойч үед монгол аймгуудын дунд өргөн дэлгэрч, удтал хэрэглэгдсээр ирсэн юм.⁴ Монгол орны нийгэм-эдийн засгийн хөгжил, хэл соёлын болон төр ёсны уламжлалын аймагт түрэг, ялангуяа уйгурын нөлөө их хэмжээгээр өвлөгдөн үлдсэн байв. Кидан нар төр улс байгуулах цагтаа Ар Монголд байсангүй, Өвөр Монголын зүүн өмнөд хэсгийн Жуудын чуулган, Ляохэ гол хэмээх зүүн Шар мөрний сав газарт нутаглаж байсан юм. Кидан улсын ууган нийслэл Бор хот нь Зүүн Шар мөрний хойд талд байсан бөгөөд Умард Хятадыг эзэлсний дараа Киданы Ляо гүрний хаад Бээжингээр төв нийслэл хийж, улс төрийн талаар тэнд гол төлөв төвлөх болсон юм. Кидан гүрний бүрэлдүүнд нийт Ар Монгол орж байсангүй, түүний зөвхөн дорнод ба өмнөд хэсэг багтаж байсан учир одоо гийн манай улсын төв, баруун ба умард хэсэгт Зүбү-татарын хаант улс

² А. Рона-Tas, Some notes on the terminology of Mongolian writing, "AO112, t. XVIII, 1965, pp. 119—147.

³ Х. Пэрлээ. Хятан нар, тэдний монголчуудтай холбогдсон нь. УБ., 1959, 35, 84 — 87, 94 — 95-р тал.

⁴ Уйгуржин монгол бичгийн үг, аялгуу тэмдэглэх хэлбэрийг Орхоны түрэгийн хээс илүү эртнийх гэж зарим эрдэмтэд үзэж байгаа тул түүнийг Монголд уйгуруу" даас урьдаар монгол угсааны ямар аймаг анх авч хэрэглэж байв? гэдэг асуудал байна.

зэрэг бусад монгол, түрэг угсааны улс ханлигууд оршин тогтнож байв.⁵ Ляо гүрний төрийн засаг захиргааны байгуулал, цааз хууль зэрэгт Хятадын нөлөө багагүй байсан, Киданы төрийн их бичиг хэмээх гол бичиг нь Хятадын дүрс үсгийн үндсэн дээр зохиогдсон боловч ялангуяа анхны үест Киданы төр ёс, соёлын аймагт ууган Монгол орных нь урьдын уламжлал ихээхэн хүчтэй хэвээр байсан юм. Л. Лигети нарын зэрэг зарим эрдэмтдийн үзэж байгаагаар Киданы бага бичиг нь уйгуржин үсэг байсан байж магад ажээ. Ямар боловч кидан, язгуурын монголчуудын улс төрийн тавцан дээр гарч ирсэн цагаас эхлэн Монгол оронд Монголын төр ёсны ба хэл соёлын уламжлал улам бэхжин дэлгэрсэн талтай юм.

Умард Хятадад эхлээд Киданы Ляо улс, түүний дараа XII-XIII зууны эхээр манж-түнгүс угсааны Зүрчидийн Алтан улс ноёлж байхад Монгол оронд язгуурын Монгол буюу Хамаг Монголын ханлиг, Онгудын ханлиг гэх зэрэг феодалын түрүү үеийн Монгол угсааны бага хэмжээний хэд хэдэн хант улс нэгэн зэрэг оршин тогтнож байсан юм. Тэдгээр ханлигууд нь жирийн аймгуудын холбооноос нэлээд ялгаатай, тухайлбал тус тусдаа өөрийн хан, торгон цэрэг, хил хязгаарын харуул хамгаалалттай төр улсын бүрдлүүд байсан бөгөөд өмнөх үеийн монгол, түрэг угсааны улсуудын төр ёсны уламжлалыг өвлөж үлдсэн байв⁶.

XII зууны эцэс -XIII зууны эхээр Онон, Хэрлэн, Туулын гурван голын эхний Хамаг Монголын ханлиг улам улмаар хүчирхэг болж, бусад монгол аймаг ханлигуудыг нэгтгэн 1206 онд Монголын феодалын нэгдсэн улсыг тэрлэн байгуулсан юм. Чингис хаан тэргүүтэй Монголын феодалын нэгдсэн улс нь Хамаг Монгол, Хэрэйд, Найман, Татар, Кидан, Уйгур, Турк, Жужан, Сяньби, Хүннү нарын төр ёсны байгууллаар суурилан түүнийг цаашид улам бэхжүүлж хөгжүүлсэн юм. Феодалын Монгол улс Орхоны хөндий дэх Хархорумд төвлөн нийслэлсэн өөрийн төрийн тэргүүн эзэн хаан, засгийн газрын тэргүүн «гован» хэмээх ерөнхий сайд, түүнчлэн мөн төрийн бэл хэмээх цаг тооны бичиг, тэнгэрийн зурхай, мэргэ төлөг, ёслол эрхэлсэн тусгай түшмэл болон төрийн заргачтай, гадаад харилцааны ажилд зүтгэдэг элч төлөөлөгчид, дипломат харилцааны өвөрмөц ёс гуриантай байсан байна. Монголын төр нь уйгуржин монгол бичгээр төрийн албаны бичиг болгосон, «Их засаг» гэдэг феодалын засаг заслалын хатуу чанга цааз хуультай байсан байна. XIII-XIV зууны Монголын феодалын эзэнт гүрний үед Монголын төр ёсонд гадаад улс орны зарим нөлөө туссан боловч үндэсний шинж чанар нь хэвээр үлдсэн байв.

XIV-XVII зууны Монголын феодалын бутралын үед Монголын төр ёсны уламжлал тасраагүй, бидний бодоход зарим талаар улам нарийсан хөгжиж байсан талтай юм.⁷ Тухайн үед Монгол улс нь анхандаа Зүүн, Баруун Монгол болж хоёр хуваагдаад түүний дараа Зүүн Монгол нь дотроо зүүн гурван түмэн, баруун гурван түмэн болж хуваагдан байв. Гэвч тийм нөхцөлд ч гэсэн Монгол орон нь нэрийн төдий боловч түүний төрийн тэргүүн болох хаантай, Хархорум ба түүний орчин тойронд улс төрийн төв нийслэл буюу хааны өргөө ордонтой, төрийн тамга, туг сүлдтэй байсан юм. Хааны засаг, төвийн захиргаа хэдийгээр сул, зарим

⁵ Н. Ишжамц, Монголд нэгдсэн төр байгуулагдаж, феодализм бүрэлдэн тогтсон нь. УБ., 1974, 4, 30-р тал.

⁶ Ш. Нацагдорж, Монголын феодализмын үндсэн замнал, УБ., 1978, 46-47-р тал..

⁷ История Монгольской Народной Республики, Совместный труд Монгольских и советских ученых, одготомник, издание третье, переработанное и дополненное. М., 1983, с. 581.

үед ерөөс нэрийн төдий болж байлаа ч гэсэн феодал ноёд нь түүний хаанчлал, засаглан захирах ёсыг дуртай ч, дургүй ч их бага алив хэмжээ байдлаар ихэнхдээ эрхбиш зөвшөөрөн хүлээхэд хүрч байсан юм. Түүнээс гадна, XV зууны тэргүүн хагасад Баруун Монгол буюу Ойрадын Тогоон тайш, Эсэн хаан нар Монголын төрийн нэгдмэл байдлыг сэргээх оролдлого хийсэн, XV зууны дэд хагас, XVI зууны эхээр Мандухай цэцэн хатан, Батмөнх Даян хаан нар Монголын төрийн нэгдмэл байдлыг нэг хэсэгтээ сэргээж чадсан, XVI зууны дэд хагас, сүүлч үеэр Түмэн засагт хаан төв засгийн газрыг сэргээн байгуулж, Төвдтэй улс төрийн холбоо байгуулан буддийн шашныг төрийн шашин болгон хэрэглэж, улс орны нэгдмэл байдлыг сэргээн бэхжүүлэх бодлого явуулж байсан байна.

XVII зууны эхэн үеэс мөн зууны 30-аад оныг хүртлэх хугацаанд Монгол улс нь Ар, Өвөр, Баруун Монгол болж гурав хуваагдсан байна. Тухайн үед Монголын төрийг Лигдэн хаан тэргүүлж, Цахарт улс төрийн төв, өргөө ордоо шилжүүлээд байсан учир Өвөр Монгол нь анхны үест бусдаас илүү хүчирхэг хаант улсын байдалтай байв. Ар Монгол буюу Халх, Баруун Монголын Ойрад нь бага хант жирийн хоёр улс ханлигууд болж үлдээд байв. Өөрөөр хэлбэл, тухайн үеийн Монголд их, бага боловч гурван улс ханлиг оршин тогтнож байсан учир төр ёсны уламжлал тасалдаагүй байжээ. 1634 — 1636 оны үест Өвөр Монгол, 1691 — 1697 оны үест Халх Монгол Манжид эзлэгдсэний дараа ч гэсэн Монголын төр Зүүнгарын хүчирхэг хаант улс байгуулагдаж XVIII зууны дунд үеийг өнгөртөл Манжийн түрэмгийллийн эсрэг баатарлаг тэмцэл хийж байв. Гагцхүү 1755— 1758 оны үест Зүүнгарын хаант улс Манжид эзлэгдэн мөхсөнөөр Монголын төр, түүний тусгаар тогтнол нэг хэсэгтээ нэлээд урт удаан хугацаагаар алдагдан тасалдсан юм.

Гэвч XVII—XVIII зууны Монголын феодалын төр улсуудыг мөхөөснөөр манж нар ерөөс Монголын төр ёсны бүх уламжлалыг бүрмөсөн тасалж чадаагүй бөгөөд тэр нь алсдаа тодорхой болсон юм. XVIII зууны дундаас XX зууны эхний Монголд үндэсний төр улс байхгүй, харь Манжийн төр ноёрхож байсан боловч монголчуудын зориг санаа, дадал зан шил, амьдрал тэмцэлд урьд үеийн төр ёсны уламжлалын үр нөлөө их хэвээр үлдэж, төр ёс, түүний тусгаар тогтнол, биеэ даасан бүрэн эрхт байдлыг сэргээх оролдлого удаа дараалан энд тэндгүй гарч, улам улмаар идэвхжиж байсан байна.

1911 онд Монгол даяар үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн хүчтэй өрнөж, Монголын төр ёс нь шашин төрийг хослон баригч феодалын богд хаант улсын хэлбэрээр сэргээж, тусгаар тогтнолыг тунхаглан зарласан юм. Тухайн үеийн нөхцөл байдалд Монгол шиг хоцрогдмол бага буурай орны тусгаар тогтнолыг сэргээж болох боломжгүй байсан боловч Монголчууд төр ёсоо нэг хэсэгтээ сэргээн байгуулж чадсан юм⁸. Богд хаант Монгол Улсын төр нь хуучин Монголын феодалын төрийн шинж чанарыг бүрэн хадгалж байсан боловч түүнд Хятадын хөрөнгөтөн, газрын эздийн түрэмгийллийн эсрэг хандсан, буддийн шашны нөлөөлөл бүхий эртний Энэтхэг, дундад зууны Төвдийн төр ёсны уламжлалын зүйл багагүй байв. Тэр бүхэн нь Монгол орны түүхэн хөгжил, дотоод гадаад байдлын онцлог байдалд зарим талаар тохирсон, хэн бүхэнд ойлгомжтой зүйл байсан боловч Хятадын цэргийн эрхтэн нар Богд хаант Монгол улсын төр,

⁸ Ш. Сандаг. Монголын улс төрийн гадаад харилцаа, тэргүүн дэвтэр. 1971, 10—12-р тал.

түүний тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй дайсагнаж байгаад 1919 онд түүнийг үнэн хэрэг дээрээ цэрэг зэвсгийн хүчээр устгасан юм.

Гэсэн ч 1921 онд Монгол Ардын нам байгуулагдаж, эзэрхэг түрэмгий ба феодалыг эсэргүүцсэн үндэсний ардчилсан хувьсгал ялан мандах хувьсгалт Монгол Улс байгуулагдаад Монголын төр ёсны уламжлал шинэ үндсэн дээр сэргэн мандсан юм. Хувьсгалаас хойшхи өнгөрсөн 65 жилийн дотор Монголын ард түмний оюун билэг, бүтээлч хөдөлмөр, шургуу тэмцлийн ачаар тус орон улс төр, эдийн засаг, соёлын бүх салбарт, бахдам амжилт олж, орчин үеийн хөгжилтэй социалист орны нэг болж, төрийн бүрэн эрхт байдлаа бататган бэхжүүлсэн юм. Энэ бүхэнд ЗХУ, социалист хамтын нөхөрлөлийн бусад орнуудын интернационалч тусламж, дэмжлэг туйлын чухал үүрэг гүйцэтгэсэн юм⁹. Манай төрийн тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг дэлхийн олон улс, түүний дотор мөн Япон улс бүрэн дүүрэн хүлээн зөвшөөрч, дипломат харилцаа байгуулан, худал дааны ба соёлын харилцаа тогтоосон билээ.

БНМАУ бол ЭЗХТЗ, НҮБ-ын гишүүн бөгөөд 100 гаруй улстай дипломат харилцаатай, 30 гаруй оронтой худалдаа, эдийн засгийн харилцаатай, ЮНЕСКО зэрэг олон улсын 40 гаруй байгууллагатай соёлын харилцаатай, олон улсын 80 гаруй байгууллагын гишүүн орон болоод байна. Манай улс Ази, Номхон далайн районы аюулгүй байдал, даян дэлхийн энх тайван, улс түмний найрамдал, хамтын ажиллагааны үйл хэргийг эрхэмлэн хүндэтгэж, тодорхой санал дэвшүүлсэн орнуудын нэг юм.

Дээр дурдсан бүх зүйлээс үзэхэд БНМАУ нь урт удаан жилийн төр ёсны уламжлалтай улс орны нэг мөн бөгөөд түүний дотоод байдал бэхжин, гадаад харилцаа өргөжиж, төрийн бүрэн эрхт байдал нь улам улмаар батжиж байна гэсэн дүн шинжилгээ хийх бүрэн үндэстэй гэж үзнэ.

⁹ М. Санждорж, Ардын төрийн түүх (хөдөлмөрчин ардын хувьсгалт ардчилсан диктатур, үүсэл хөгжил ба үйл ажиллагаа), УБ., 1974, 5, 6, 293-р тал.